

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/020/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 436

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд улсын төсвөөс 859,292.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 36,473.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 140.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж гүйцэтгэлээр 817,516.1 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 0.7 мянган төгрөгийг төвлөрүүлэн улсын төсвийн харилцах дансанд 200,369.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1,291,152.7 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд 74,684.5 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1,216,468.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв хийх, үүнд тавих дотоод хяналтыг сайжруулахад онцгой анхаарах хэрэгтэй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллага 2025 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 7 зорилтын хүрээнд 74 арга хэмжээ тусгаж, 92 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>182,854,917.49</u>	<u>264,761,166.45</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	122,119,961.48	200,369,010.44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	122,119,961.48	200,369,010.44
3121	Төгрөг	122,119,961.48	200,369,010.44
31211	Төрийн сангийн харилцах	122,119,961.48	200,369,010.44
35	БАРАА МАТЕРИАЛ	60,734,956.01	64,392,156.01
351	Түүхий эд материал	167,000.00	167,000.00
35110	Тусгай зориулалттай материал	167,000.00	167,000.00
354	Хангамжийн материал	60,567,956.01	64,225,156.01
35410	Бичиг хэргийн материал	546,000.00	804,500.00
35420	Аж ахуйн материал	33,772,384.54	35,197,384.54
35440	Түлш, шатах тослох материал	4,524,000.00	1,648,000.00
35460	Хүнсний материал	6,433,600.00	11,259,300.00
35470	Бусад хангамжийн материал	15,291,971.47	15,315,971.47
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>431,548,459.87</u>	<u>404,765,335.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	431,548,459.87	404,765,335.84
392	Биет хөрөнгө	383,548,459.87	356,765,335.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	406,103,566.00	384,638,614.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(101,233,488.57)	(98,696,698.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,098,267.00	102,003,267.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,161,906.73)	(61,011,778.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,113,248.22	35,883,248.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,024,337.93)	(22,300,260.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	31,964,952.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(22,369,119.06)
39217	Ном	6,653,111.88	6,653,111.88
393	Биет бус хөрөнгө	48,000,000.00	48,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	48,000,000.00	48,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>614,403,377.36</u>	<u>669,526,502.29</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>614,403,377.36</u>	<u>669,526,502.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	614,403,377.36	669,526,502.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	228,690,952.90	228,690,952.90
51101	Өмч: - төрийн	228,690,952.90	228,690,952.90
512	Хуримтлагдсан үр дүн	244,849,108.30	299,972,233.23
51210	Өмнөх үеийн үр дүн	244,849,108.30	244,849,108.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	55,123,124.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	140,863,316.16	140,863,316.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>614,403,377.36</u>	<u>669,526,502.29</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	812,928,728.00	906,044,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,385,328.00	10,279,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	115,385,328.00	10,279,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,385,328.00	10,279,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	359,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	140,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	114,990,628.00	10,139,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	697,543,400.00	895,765,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	650,443,400.00	859,292,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	650,443,400.00	859,292,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,100,000.00	36,473,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,100,000.00	36,473,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	635,952,168.99	850,921,675.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	635,952,168.99	850,921,675.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,380,591.73	836,283,832.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	460,200,661.32	631,186,618.13
210101	Үндсэн цалин	409,360,168.32	515,064,055.45
210102	Нэмэгдэл	50,840,493.00	99,911,693.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,200,000.00
210104	Урамшуулал	-	14,010,868.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,978,097.54	78,042,072.91
210201	Тэтгэврийн даатгал	38,826,171.29	52,021,959.83
210202	Тэтгэмжийн даатгал	8,839,402.28	6,475,298.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,179,739.64	3,584,793.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,141,714.59	3,223,501.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,991,069.74	12,736,520.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,778,122.74	31,054,107.25
210301	Гэрэл, цахилгаан	3,676,422.74	4,822,507.25
210302	Түлш, халаалт	25,723,700.00	26,057,600.00
210303	Цэвэр, бохир ус	378,000.00	174,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,408,300.00	-
210401	Бичиг хэрэг	1,408,300.00	-
2105	Нормативт зардал	28,952,420.00	20,739,210.00
210502	Хоол, хүнс	28,952,420.00	20,739,210.00
2107	Томилолт, зочны зардал	870,000.00	-
210702	Дотоод албан томилолт	870,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,032,008.80	17,520,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,032,008.80	17,520,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,160,981.33	57,741,324.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,877,314.57	15,783,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,884,300.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,399,366.76	41,958,124.03

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,571,577.26	14,637,842.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	14,637,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	13,316,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,320,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,571,577.26	692.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,571,577.26	692.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>176,976,559.01</u>	<u>55,123,124.93</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>176,976,559.01</u>	<u>55,123,124.93</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	697,938,100.00	895,905,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	394,700.00	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	394,700.00	140,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	394,700.00	140,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	359,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	697,543,400.00	895,765,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	650,443,400.00	859,292,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	650,443,400.00	859,292,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,100,000.00	36,473,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,100,000.00	36,473,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	612,161,079.49	812,596,751.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	612,161,079.49	812,596,751.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	592,556,774.97	798,760,558.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,563,413.52	631,186,618.13
210101	Үндсэн цалин	286,791,027.30	372,160,933.45
210102	Нэмэгдэл	157,376,988.95	226,219,065.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,200,000.00
210104	Урамшуулал	13,395,397.27	30,606,618.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,615,345.34	78,042,072.91
210201	Тэтгэврийн даатгал	38,216,572.24	52,021,959.83
210202	Тэтгэмжийн даатгал	4,921,843.23	6,475,298.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,613,862.01	3,584,793.08
210204	Ажилгүйдлийн даатгал	2,444,333.49	3,223,501.37
210205	Эрүүл мэндийн даатгал	9,418,734.37	12,736,520.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,903,422.74	27,973,007.25
210301	Гэрэл, цахилгаан	3,676,422.74	4,822,507.25
210302	Түлш, халаалт	27,849,000.00	22,956,500.00
210303	Цэвэр, бохир ус	378,000.00	194,000.00
2105	Нормативт зардал	16,321,370.00	26,366,560.00
210502	Хоол, хүнс	16,321,370.00	26,366,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,625,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	10,625,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,029,123.37	6,217,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	359,700.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,669,423.37	6,217,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,499,100.00	24,975,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,614,800.00	23,033,020.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,884,300.00	1,942,180.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,604,304.52	13,836,192.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,461,150.00	13,835,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,461,150.00	12,514,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,320,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,143,154.52	692.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,143,154.52	692.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>85,777,020.51</u>	<u>83,309,048.96</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	5,060,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,060,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,060,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	5,060,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(5,060,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	85,777,020.51	78,249,048.96
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		122,119,961.48
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	122,119,961.48	200,369,010.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-		-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-		-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,690,952.90	140,863,316.16	244,849,108.30	-	614,403,377.36
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	228,690,952.90	140,863,316.16	244,849,108.30	-	614,403,377.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	228,690,952.90	140,863,316.16	244,849,108.30	-	614,403,377.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	55,123,124.93		55,123,124.93
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,690,952.90	140,863,316.16	299,972,233.23	-	669,526,502.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	965,425,600.00	817,516,058.29	147,909,541.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	965,425,600.00	817,516,058.29	147,909,541.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	951,581,900.00	803,680,558.29	147,901,341.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	747,897,500.00	631,186,618.13	116,710,881.87
210101	Үндсэн цалин	418,894,000.00	374,860,933.45	44,033,066.55
210102	Нэмэгдэл	295,760,100.00	223,519,065.71	72,241,034.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,200,000.00	(2,200,000.00)
210104	Урамшуулал	33,243,400.00	30,606,618.97	2,636,781.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,487,000.00	78,042,072.91	15,444,927.09
210201	Тэтгэврийн даатгал	63,571,300.00	52,021,959.83	11,549,340.17
210202	Тэтгэмжийн даатгал	7,479,000.00	6,475,298.45	1,003,701.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,739,400.00	3,584,793.08	154,606.92
210204	Ажилгүйдлийн даатгал	3,739,400.00	3,223,501.37	515,898.63
210205	Эрүүл мэндийн даатгал	14,957,900.00	12,736,520.18	2,221,379.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,973,700.00	27,973,007.25	692.75
210301	Гэрэл, цахилгаан	5,977,200.00	4,822,507.25	1,154,692.75
210302	Түлш, халаалт	21,916,500.00	22,956,500.00	(1,040,000.00)
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	194,000.00	(114,000.00)
2105	Нормативт зардал	41,688,000.00	26,366,560.00	15,321,440.00
210502	Хоол, хүнс	41,688,000.00	26,366,560.00	15,321,440.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00	8,500,000.00	-
210604	Урсгал засвар	8,500,000.00	8,500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,476,100.00	6,217,100.00	259,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,476,100.00	6,217,100.00	259,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,559,600.00	25,395,200.00	164,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,992,700.00	22,893,020.00	99,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,566,900.00	2,502,180.00	64,720.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,843,700.00	13,835,500.00	8,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,843,700.00	13,835,500.00	8,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,523,000.00	12,514,800.00	8,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,320,700.00	1,320,700.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	965,425,600.00	895,765,107.25	69,660,492.75
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	928,951,900.00	859,292,100.00	69,659,800.00

131001	Улсын төсвөөс санхүүжих	928,951,900.00	859,292,100.00	69,659,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,473,700.00	36,473,007.25	692.75
132001	Орон нутгийн төсвөөс	36,473,700.00	36,473,007.25	692.75
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		122,119,961.48	(122,119,961.48)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		200,369,010.44	(200,369,010.44)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын явцад 74,684.5 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлан дахь аж ахуйн материал дансны эхний үлдэгдэл 19,1 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал дансны эхний үлдэгдэл 300.0 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас дутуу илэрхийлэгдсийг нэмэгдүүлж залруулсан.
- Санхүүгийн тайлан дахь машин тоног төхөөрөмж /компьютер/ дансны эхний үлдэгдэл 7,143.8 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас илүү илэрхийлэгдсэнийг бууруулж, тавилга эд хогшил дансны эхний үлдэгдэл 5,200.0 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас дутуу илэрхийлэгдсэнийг нэмэгдүүлж залруулсан.
- Санхүүгийн тайлан дахь Барилга, байгууламж, орон сууц дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 12,920.8 мянган төгрөгөөр, Машин тоног төхөөрөмж /компьютер/ дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 2,370.1 мянган төгрөгөөр, Тавилга, аж ахуйн эд хогшил дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 2,568.2 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас дутуу илэрхийлэгдсэн, тухайн дансдын тайлант хугацааны элэгдлийн зардлыг 10,256.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг нөхөн тооцуулж залруулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 444.7 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 33,046.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан, төвлөрүүлэх шилжүүлгийн тохиргоо бичилт хийгдээгүй байсныг тохируулж залруулсан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 415.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг нэмж орлогод аван залруулсан.

3.1 Төлбөрийн акт

Байхгүй.

Аудитаар нийт 1,216,468.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв.

3.2 Албан шаардлага

- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тухайн сарын тооцоолсон цалингийн зардлаас зөрүүтэй тайлагнаж байна. /ажилчдын төлсөн НДШ-ийг огт тайлагнахгүй байх, тооцоолсон цалингаас илүү, дутуу тайлагнах, ажлаас чөлөөлөгдсөн хүн дээр НДШ тооцож тайлагнах гэх мэт/ Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.
- Шилэн дансны цахим сайтад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулаагүй, төсвийн гүйцэтгэлийн мэдээг тогтмол хугацаа хоцроон оруулах, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын дүн оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээний мэдээлэл, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээллийг дутуу мэдээллэх зэргээр хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлж байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “ Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 7 дугаар зүйлийн 7.1.-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.1-т “Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн

гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан" гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.3 Зөвлөмж

Байхгүй.

*Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшинд хамаарахгүй тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын эхний үлдэгдлийг дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй тайлагнасан	1	319.1			1	319.1	1	319.1				
Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй тайлагнасан	1	12,343.8			1	12,343.8	1	76.0				
Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн	1	33,490.8			1	33,490.8	1	33,490.8				
	1	415.0			1	415.0	1	415.0				
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон	1	28,115.8			1	28,115.8	1	28,115.8				
Дүн	5	74,684.5			5	74,684.5	5	74,684.5	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг тооцсон цалингаас зөрүүтэй тайлагнасан	1	0			1	0						
Дүн	1	0			1	0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн	1	1,216,468.2			1	1,216,468.2		
Дүн	1	1,216,468.2			1	1,216,468.2		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 223 - А2371281

Чингис хот

ХЭА - 2026/020/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тухайн сарын тооцоолсон цалингийн зардлаас зөрүүтэй тайлагнаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тооцоолсон цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирал Д.Солонго, нягтлан бодогч М.Хангай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 224 - А2371281

Чингис хот

ХЭА - 2026/020/НА - СТА - ТШЭ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим системд 1,216,468,220.00 (нэг тэрбум хоёр зуун арван зургаан сая дөрвөн зуун жаран найман мянга хоёр зуун хорь) төгрөгийн мэдээллийг дутуу байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 7 дугаар зүйлийн 7.1-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.1-т "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн байршуулдаггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирал Л.Солонго, нягтлан бодогч М.Хангай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР